



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/121

Мөрөн сум

Сургалтад хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 376 дугаар тогтоолын 3.6 дах хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албаны тухай хууль болон Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Цэргийн штабын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсугай.

2.Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

3.Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтад хамрагдах үеийн сахилга, зохион байгуулалтыг чанд сахин нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг цэргийн штаб (хурандаа С.Батхуяг)-т даалгасугай.

4.Сургалтад хамрагдах сумдын Засаг даргын Тамгын газрын дарга (даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) нарыг ЗХЖШ-ын даргын 2021 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийн дагуу хээрийн хувцас, хагас түрүүтэй гутлаар ханган ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6712010398

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 27-ны /12/ дугаар
захирамжийн хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТАЙ ЯВУУЛАХ “ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ”
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Зорилго:

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын Батлан хамгаалах хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг удирдан зохион байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангахад оршино.

Хамрагдах бүрэлдэхүүн: Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар

Явуулах хугацаа байрлал:

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын “Иргэний танхим”-д 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулна.

№	Явагдах арга хэмжээ	Хугацаа	Явуулах газар	Хариуцах албан хаагч
1	Сумдын Засаг даргыг Тамгын газрын дарга нарыг бүртгэх	08.30-09.00	Нутгийн удирдлагын ордон	Дэд хурандаа Ү.Батбаяр
2	Сумдын Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтын нээлтийн ажиллагаа	09.00-09.10	Засаг даргын Тамгын газрын “Иргэний танхим”-д	Цэргийн штабын дарга
3	Сумдын Засаг дарга нарт сургалтын хөтөлбөр, цагийн хуваарийг танилцуулах	09.10-09.20		Дэд хурандаа Т.Анхбаяр
4	Монгол Улсын Батлан хамгаалах бодлого	09.20-10.00		Хурандаа С.Батхуяг
5	Дайчилгааны дайчилгааны тухай хуулийн танилцуулга,	10.00-10.40		Дэд хурандаа Б.Мөрөндалай
6	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн танилцуулга	10.40-11.20		Дэд хурандаа Т.Анхбаяр
7	Завсарлага	11.20-11.40		Цэргийн штаб
8	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт	11.40-12.50		Архивын тасаг Г.Ням-Эрдэнэ
9	Өдрийн хоол	13.00-13.50	“Өргөө” ХХК	Цэргийн штаб
10	Төрийн болон албаны нууцын талаар	14.00-14.50	“Иргэний танхим”-д	Тагнуулын хэлтэс
11	Цэргийн тоо бүртгэл явуулах журам	14.55-15.40		Дэд хурандаа Ү.Батбаяр
12	Хүн нэг бүрийн буудлага хийх	16.00-17.30	Буудлагын талбай	Дэд хурандаа Т.Анхбаяр
13	Дурсгалын зураг авхуулах	17.30-18.00	Нутгийн удирдлагын ордон	Цэргийн штаб
14	Дүн гаргах	18.00-18.30	“Иргэний танхим”-д	ОНХБ, сургалтын офицер дэд хурандаа Т.Анхбаяр